

АГУУЛГА

1.	Төслийн товч танилцуулга	4
1.1.	Компанийн товч танилцуулга	4
1.2.	Төслийн зорилго.....	4
1.3.	Ордын нөөц.....	4
1.4.	Төслийн байршил.....	5
1.5.	Далд уурхайн одоогийн байдал	5
1.6.	Далд уурхайн ашиглалтын системийн сонголт	6
1.7.	Далд уурхайн хүчин чадал, ажиллах горим	7
1.7.1.	Далд уурхайн барилга байгууламж	8
1.8.	2026 оны уулын ажлын төлөвлөгөөний товч.....	8
2.	Бүс нутгийн мэдээлэл, хүн ам, эдийн засгийн төлөв байдлын товч.....	9
2.1.	Байгаль орчин.....	9
2.2.	Газарзүй, хөрс, ургамал, амьтан	9
2.3.	Эдийн засгийн байдал.....	10
2.4.	Засаг захиргаа, хүн ам	10
3.	Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	12
3.1.	Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл	12
3.2.	Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл.....	12
3.3.	Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл.....	12
3.4.	Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл	13
3.5.	Гадаргын болон гүний усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	13
3.6.	Нийгэм, эдийн засгийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл.....	13
3.7.	Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	13
3.8.	Түүх соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөлөл	14
3.9.	Цацраг идэвхт бодисын нөлөөлөл	14
4.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулга	15
4.1.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулсан аргачлал	15
5.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
6.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	19
7.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ..	19
8.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	20
9.	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20

10.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	21
11.	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	22
12.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	24
13.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	25
14.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	26
	уул уурхайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас .	28
	Нэг. Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд, төслийн тухай товч мэдээлэл.....	28
	Хоёр. Төсөл хэрэгжүүлэх чиглэлээр олгогддог тусгай зөвшөөрөл, дүгнэлт, лавлагааны товч мэдээлэл.....	30
	Гурав. Химийн бодисын эрсдэл, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	31
	Дөрөв. Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн төсөв	32
	Тав. Мета мэдээлэл	33
	Зургаа. Тухайн жилийн арга хэмжээнээс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээний хяналтын хуудас	34
	Долоо. Байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дүн шинжилгээний хяналт	35
	Найм. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний хяналтын хуудас	36

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
Хүснэгт 2. Нөхөн сэргээх талбайн хэмжээ	19
Хүснэгт 3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
Хүснэгт 4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт 5. 2026 оны Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	22
Хүснэгт 6. Тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваар	24
Хүснэгт 7. Хог хаягдлыг бууруулах болон устгах арга хэмжээ.....	25
Хүснэгт 8. Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	26

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Уурхайн байршлын зураг.....	5
Зураг 2. Газрын гадаргуугийн одоогийн байдал	6

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Компанийн товч танилцуулга

Төслийн нэр:	“Бор-Өндөрийн хайлуур жоншны хүдрийн 16-1 биетийг далд аргаар ашиглах” төсөл
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:	“Си Эм Кэй Ай” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9019046024
Регистрийн дугаар:	5288703
Ашигт малтмалын дугаар:	MV-016772 /30.75 га/
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 7-р хороо, 2.

“Си Эм Кэй Ай” ХХК нь 2009 оноос эхлэн хайлуур жоншны хүдрийн ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж юм. Тус компани нь Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Хүдрийн биет 16 1” нэртэй ашиглалтын MV-016772 тоот тусгай зөвшөөрлийг 2011 оны 01-р сарын 31-ний өдрийн АМГТГ-ын Хэлтсийн даргын 274 тоот шийдвэрээр авсан байна.

1.2. Төслийн зорилго

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших MV-016772 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд байх Бор-Өндөрийн хайлуур жоншны ордын хүдрийн 16-1 биетийг Монгол улсын хууль, холбогдох дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэй байхаар уурхайн ашиглалт явуулах цаашлаад улс, орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг хийж, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэг нь энэ төслийн зорилго оршино.

1.3. Ордын нөөц


“Хүдрийн биет-16-1” ордын нөөцийг далд уурхайн аргаар ашиглахаар тооцсон бөгөөд ашиглалтын нөөц нь бодитой (В) болон боломжит (С) зэргээр тогтоогдсон.

Далд уурхайн ашиглалтын нөөц нь нийт (В+С) зэргээр 120.6 мян.тн хүдэр бөгөөд дундаж агуулга (CaF₂) 37.5% байна. Үүнд:

1. Бодитой (В) зэргийн нөөц – 112.8 мян.тн
2. Боломжит (С) зэргийн нөөц – 7.8 мян.тн
3. Нийт хайлуур жоншны нөөц – 45.3 мян.тн

1.4. Төслийн байршил

“Бор-Өндөрийн хайлуур жоншны хүдрийн биет 16-1” ордын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 330 км, Бор-Өндөр сумын төвөөс зүүн хойш 3 км зайд байрлана. Талбай нь номенклатурын хувьд L-49-63 хавтгайд байрладаг.



Зураг 1. Уурхайн байршлын зураг

1.5. Далд уурхайн одоогийн байдал

Хүдрийн биет-16-1 талбай дахь хүдрийн 16-р биетэд олборлолтын үйл ажиллагаа огт явуулаагүй бөгөөд уурхайн талбайд “Си Эм Кэй Ай” ХХК-ийн жилд 150.0 мян.тн хайлуур жоншны хүдэр флотацийн аргаар баяжуулах үйлдвэрийг барин үйл ажиллагаа явуулж байна.


Баяжуулах үйлдвэрийн дэргэд хаягдлыг хуримтлуулах 244 м урт, 144 м өргөн, хамгийн ихдээ 12 м өндөр, 421.6 мян.м³ эзлэхүүнтэй хаягдлын санг байгуулсан байна. Хаягдлын санг “Усны Эрчим” ХХК-ийн боловсруулсан төсөлд үндэслэн гүйцэтгэсэн байна. Хаягдлын санг байгуулахдаа далангийн их биеийг тохирох хөсрөөр байгуулж, сан болон даланг 0.2 м зузаантай элсээр бүрэн хучиж, түүний дээр 300 гр/см² геотекстил ба 1.5 мм зузаантай геомембранаар доторлон байгуулсан байна.

Жонш баяжуулах үйлдвэрийн хүрээнд уурхайн талбайд захиргаа, ахуйн байр, хурлын өрөө, оффис өрөө, амрах өрөө, хоолны заал, ариун цэврийн өрөө, халуун усны

өрөө бүхий 680 м² талбайтай сэндвичэн, иж бүрэн тохижуулсан кемпийг 2023 онд байгуулсан байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хойд хэсэгт нийт 470 м² талбай бүхий ажилчдын сэндвичэн кемп, 500 м² талбай бүхий спорт тоглоомын талбай, 300 м² талбай бүхий ногооны талбай зэргийг байгуулан ашиглалтад оруулсан байна. Мөн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн баруун захад 0.7 га талбай бүхий талбайд тэсрэх материалын агуулахуудыг стандартын дагуу барьж байгуулан улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

2014 онд ЭХЯ-ны шийдвэрийн дагуу цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг гаргуулан Бор-Өндөр сумын 110/35/6 кВ-ын “Бор-Өндөр” дэд станцаас 35 кВ-ын агаарын шугам татаж, 35/0.4 кВ-ын дэд станцыг байгуулан үйлдвэр, уурхайн цахилгаан хангамжийг бүрэн шийдсэн байна.

Ордын талбайд 2024 оны 04-р сард “Хясаат ахуун” ХХК ажиллаж маркшейдерийн хэмжилтийн ажлыг гүйцэтгэсэн байна. Уг хэмжилтээр төслийн талбай дээрх объектууд, газрын гадаргуугийн байдал зэргийг эцсийн байдлаар хэмжжээ.



Зураг 2. Газрын гадаргуугийн одоогийн байдал

1.6. Далд уурхайн ашиглалтын системийн сонголт

“Хүдрийн биет-16-1” ордын хүдрийн биет нь дунджаар 78° уналын өнцөгтэй, эгц байрлалтай, 2.65 м орчим зузаантай, чулуулгийн бат бөхийн коэффициент 7.7 бүхий бат бөх чулуулгийн орчинд байрлаж байна. Ийм геологийн болон уул техникийн нөхцөлд хүдэр хоршоолох ашиглалтын системийг хэрэглэх нь хамгийн тохиромжтой гэж үзсэн.

Хүдрийг хоршоолох ашиглалтын системийг хэрэглэх үед блокийг бэлтгэхдээ хүдрийн биетэд параллель чиглэлд хээрийн штрек малталтыг хоосон чулуулаг дундуур нэвтрүүлж, түүнээс орт малталтуудыг хүдрийн биетэд перпендикуляр чиглэлээр нэвтрүүлнэ. Мөн блокийн захаар восстающий малталтуудыг хүдрийн биет дундуур нэвтрүүлж, огтлол штрек малталтуудыг үе шаттайгаар байгуулснаар блокийн бэлтгэл ажлыг хангана. Восстающий газрын гадаргууд хүргэж, агааржуулалт болон тээвэрлэлтийн нөхцөлийг бүрдүүлэн нөөц гарц болгон ашиглана.

Тус ашиглалтын системийг хэрэглэхэд хүдрийн биетийн уналын өнцөг 55° -аас дээш, олборлох зузаан нь 1.0 м-ээс их, чулуулгийн тогтвортой байдал хангалттай байх шаардлагатай бөгөөд ордын нөхцөл эдгээр шаардлагыг бүрэн хангаж байна.

Бэлтгэл ажлын хүрээнд блок доторх холбоос малталтуудыг тодорхой зайтайгаар нэвтрүүлж, хүний явуулыг налуу байрлалтайгаар зохион байгуулна. Олборлолтыг хэвтээ үеэр, дунджаар 1.5–2.5 м өндөр үеэр явуулах ба өрөмдлөг, тэсэлгээний аргаар хүдрийг нураан олборлоно. Өрөмдлөгийн өмнө ажлын талбайн аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай тохиолдолд бэхэлгээ хийж ажиллана.

Тэсэлгээний дараа хүдрийн тодорхой хэсгийг эхний ээлжид буулгаж, блокийн нөөцийг бүрэн нураасны дараа үлдсэн хүдрийг бүрэн буулган олборлоно. Блокийн хэмжээг хүдрийн биетийн тогтоцоос хамааран ойролцоогоор 40 м өндөр, 45–50 м урт байхаар сонгосон бөгөөд олборлолтыг мөчлөгт горимоор явуулна.

Олборлолтын явцад хажуугийн чулуулгийн тогтворжилтыг хангах шаардлагатай тохиолдолд бэхэлгээ хийж, аюулгүй ажиллагааг мөрдөн ажиллана. Мөн хүдрийг буулгах явцад мөргөцөгт нэвтрэхийг хориглох зэрэг аюулгүй ажиллагааны шаардлагыг чанд мөрдөнө.

1.7. Далд уурхайн хүчин чадал, ажиллах горим

Далд уурхайн хүчин чадал: Далд уурхайн олборлолтын хүчин чадал нь геологи, уул техникийн нөхцөл, малталт нэвтрэлтийн ажлын хэмжээ, олборлолтын технологи болон тоног төхөөрөмжийн уялдаа зэргээс хамаарч тодорхойлогдоно.

Тухайн ордын хувьд хүдрийн биетийн зузаан, уналын өнцөг, чулуулгийн шинж чанарт тулгуурлан далд уурхайн жилийн хүчин чадлыг тооцоолсон бөгөөд уурхайн хүчин чадлыг тогтвортой хангах зорилгоор олборлолт, бэлтгэл малталт, тээвэрлэлт, агааржуулалт зэрэг ажлуудыг уялдаа холбоотой зохион байгуулна. Мөн тоног төхөөрөмжийн сонголт, ашиглалт, ажиллах хүчний зохион байгуулалтыг оновчтой төлөвлөснөөр уурхайн хүчин чадлыг жигд, тасралтгүй хангах нөхцөл бүрдэнэ.

Далд уурхайн ажиллах горим: Далд уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлж бүр 8 цагийн үргэлжлэх хугацаатайгаар ажиллахаар төлөвлөсөн. Жилийн нийт 365 хоногоос амралтын болон цаг агаарын саатлын хоногийг хасаж тооцоход жилд 335 хоног ажиллах горимтой байна.

Ээлжийн хугацаанд бэлтгэл, завсарлага болон сул зогсолтыг тооцсоны дараа ээлжийн цэвэр ажиллах хугацаа дунджаар 6.17 цаг бөгөөд ээлжийн цаг ашиглалт 77% байна. Ийнхүү уурхайн жилийн нийт цэвэр ажиллах цаг 4132 цаг байна.

1.7.1. Далд уурхайн барилга байгууламж

Уурхайн бэлтгэл ажлын хүрээнд уурхайн барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулаад байна. Уурхайн хотхонд дунджаар 80 хүн амьдрах ажилчдын амрах байр, хотхоны гал тогоо, халуун ус, спорт талбай, машины зогсоол, граж, агуулах зэргийг барьсан. Төслийн талбайн дэд бүтцийн хүрээнд дараах барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулж улсын комиссоор оруулсан. Үүнд:

- Ажиллах хүчний орон сууц, үйлчилгээний байгууламж
- Оффис
- Засварын газар
- Тэсрэх материалын агуулах
- Бусад инженерингийн байгууламжууд

1.8. 2026 оны уулын ажлын төлөвлөгөөний товч

2026 онд В-2 хүдрийн биетийн В-1, В-2, В-3, В-4, В-5 дугаар блокуудыг ашиглана. ТЭЗҮ-ийн төслөөр ордыг далд аргаар ашиглахаар тооцсон байна. Ордыг нээхдээ босоо гол амаар нээж ашиглахаар тооцсон байна. 2026 онд:

- ЭБМЗ-ийн 2010 оны 06-р сарын 18-ны өдрийн ХХ-08-08 тоот дүгнэлтээр хүлээн авч, Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн нөөцийн бодитой В зэргийн 124.5 мян.тн хайлуур жоншны хүдрийн нөөцөөс 45 мянган тонн үйлдвэрлэлийн нөөцийг ашиглах ба дундаж агуулга 39.42 хувь, хайлуур жонш 17.74 мян.тонн ,
- Хүдэр хоршоолох ашиглалтын системийг ашиглахаар төлөвлөсөн,
- Тухайн жил нэг босоо ам шинээр гаргаж, 250 м тээврийн штрех бэлтгэл малталтын ажил хийх ба 680 м³ .
- Байгаль орчин нөхөн сэргээлтийн сэргээлтээр уурхай болон баяжуулах үйлдвэр нийлээд 1000 мод тарихаар төлөвлөсөн.
- Өөрийн үйлдвэрт нийлүүлэх тул ямар нэг ялгалт хийхгүй байна.

2. БҮС НУТГИЙН МЭДЭЭЛЭЛ, ХҮН АМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ

2.1. Байгаль орчин

Уур амьсгал: Судалгааны талбай нь жилийн дөрвөн улирал ээлжлэн солигддог эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын температурын зөрүү их. Өвөл нь -37.50 хүртэл хүйтэрнэ. Зун хамгийн их халж +34.90С -ээс +400С хүрнэ. Жилд унах хур тунадасны хэмжээ дунджаар 277 мм бөгөөд үүний 70 гаруй хувь нь зуны улиралд бууна. Жил бүрийн 10-р сарын сүүл үеэс цас орж хүйтний улирал эхэлдэг. Салхины хурд 3-5 м/сек-ээс 18 м/сек хүрнэ. Заримдаа түүнээс ч хүчтэй шороон шуурга шуурна.

Уул зүй: Энэ нутаг нь газар зүйн бүсийн ангиллаар хээр талын бүсэд хамрагдана. Тус нутагт өндөр уул нуруу, гол мөрөн байхгүй. Газрын гадаргуу нь жижиг гүвээ, толгод, тэгшивтэр тал гадаргаас бүрдэнэ. Хэнтий аймгийн Бор Өндрийн нутаг дэвсгэрт оршиж буй тус талбай нь 1280-1400 м-ийн өндөрлөгтэй уул толгод, ухаа гүвээ тэдгээрийн хоорондох тэвш маягийн хөндий тал зонхилсон тал хээрийн бүсэд хамаарагдана. Талбайн хэмжээнд хамгийн өндөрлөг цэг нь 1447.56 м өндөртэй Их бор овоо, хамгийн нам дор цэг нь 1271.1 м өндөрлөг бүхий Бор өндрийн булгийн хөндий юм. Уулс хяр толгодын орой тэгш мөлгөрдүү гадаргатай, хааяа 0.6-1.2 м өндөртэй цахиурлаг чулуулгаас тогтсон дэл, судал тод ялгарч харагддаг.

2.2. Газарзүй, хөрс, ургамал, амьтан

Газар зүй: Газарзүйн байршил нь Хэнтий аймгийн баруун өмнөд хэсэгт урд талаараа Дорноговь аймгийн Айраг сум, бусад хэсгээрээ Дархан сумтай хиллэдэг. Байгаль, газарзүйн онцлог нь далайн түвшнээс дээш 1000-1500 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд Монголын Дорнод талын их мужийн халхын дундад ухаа гүвээт талын тойрогт, Байгалын бүсийн хувьд хуурай хээрийн бүсэд тус тус багтдаг. Тус суманд өвөрмөц тогтоцтой газар олон байдаг. Үүнээс дурдвал Бор-Өндөр, Өлгий, Бумбат зэрэг далайн түвшнээс дээш 1400-1600 метрт өргөгдсөн уул хайрхнууд бий.

Ургамал: Тус сумын нутаг ботаник газар зүйн мужлалаар дээгүүр, Монголын хээрийн тойргийн Нялгын районд хамаарна. Уулын хээрт: Цахилдаг, алаг өвст, хиаг-хялганат, бужмаг, хонгорзул, улалж, бут бударгана, харгана, халгай, буурцагт өвсний төрөл зонхилно. Тал хээрт: Үетэн хялганат, хазаар өвс, хиаг-хялганат, шарилж, лууль, дэрс болон амт чанар, шимт сайтай үетэн, буурцагт, алаг өвсний төрлийн ургамал зонхилно. Мөн гол, булаг, нуур тойрмын хөвөөгөөр хиаг, хазаар өвс, салхин ерхөг, дэрс, харгана,

адамсын агь, хэрс зэрэг ургамал ургадаг ба сумын урд говирхог талаараа таана, мангир, хөмүүл, ерхөг, үетэн хялганат, алаг өвс, жижиг бутан үетэн, ботуульт ургамал зонхилон ургадаг байна. Сумын нийт бэлчээрийн 4.5% нь цэвэр бэлчээр, 59% нь сөөгт бэлчээр, 22% нь чулуурхаг бэлчээр, 14.5% нь довонтой бэлчээр байна. Эмийн ургамлаас: Юлдэн тарваган шийр, өргөст сарнай, нохойн хошуу, говийн ганга, таван салаа, царван, хөх дэгд, шар дэгд, цөс өвс, арц, банздоо, бошго, сөд, соргол зэрэг олон зүйлийн эмийн ургамал ургадаг.

Агнуурын ан амьтан: Чоно, үнэг, хярс, бор туулай, дорго, хүрнэ, мануул, цагаан зээр, тарвага зэрэг ан амьтан элбэг тааралдах ба сүүлийн жилүүдэд байгалийн хувьсан өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас тарвага, цагаан зээр зэрэг агнуурын ан амьтад эрс ховордсон байна. Жигүүртэн шувуу, махчин шувууд: Энэ төрлийн шувуудаас Дархан сумын нутаг дэвсгэрт бүх төрлийн бүргэд, шилийн сар, идлэг шонхор, начин шонхор, зээрд шонхор, тас, элээ, шар шувуу. Бусад элбэг шувууд: Хөхвөр тагтаа, соотон гуйвалга, хотны бүгээхэй, хэрээ, бөвөөлжин өвөөлж, болжморууд, монгол божрог, улаавар бужмар, ногтруу, тольг дунхай зэрэг шувуудаас гадна агнуурын шувууд болох дагуурын ятуу, цагаан ятуу, тоодог шувууд тааралдана.

2.3. Эдийн засгийн байдал

Хүн ам харьцангуй ихтэй, гол төлөв уул уурхайн үйлдвэрүүд болон төмөр замын өртөөнүүдэд ажил эрхэлдэг. Тус бүс нутаг нь өндөр хүчдэлд холбогдсон, төмөр замд холбогдсон, уулын баяжуулах үйлдвэртэй, дэд бүтэц сайн хөгжсөн ба эдийн засгийн хувьд таатай нөхцөл бүрдсэн нутаг юм. Бор-Өндөр сумын хэмжээнд нийт 50.9 мянган толгой малтай ба үүнээс Тэмээ-64, Адуу-1887, Үхэр-1594, Хонь-21945, Ямаа-25472, эрлийз болон нутгийн шилмэл омгийн 1.1 мянган толгой мал тоологдсон байна. Тус сум 5 га талбайд төмс, 4.3 га талбайд хүнсний ногоо тариалж, жилд дунджаар 97 тн төмс, 70 тн хүнсний ногоо хураан авдаг байна.

2.4. Засаг захиргаа, хүн ам

Засаг захиргаа: Хэнтий аймаг нь 80.3 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй 17 сум, 83 багтай. Хамгийн том газар нутагтай сум болох Өмнөдэлгэр сум нь 10.9 мянган км² нутаг дэвсгэртэй бол хамгийн жижиг газар нутагтай нь Мөрөн сум буюу 2.2 мян км² нутагтай дэвсгэртэй юм. Хойд талаараа ОХУ-тай хил залгана. Улс дотор Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр, Төв, Сэлэнгэ аймгуудтай, нийслэлийн Багануур дүүрэгтэй хиллэдэг.

Хүн ам: Хэнтий аймаг нь 77.6 мянган хүн амтай. Нийт хүн амын 50.5% нь эрэгтэй, 49.5% нь эмэгтэйчүүд тус тус байна. Хэнтий аймгийн хувьд хүн ам нь сүүлийн 5 жилийн турш тасралтгүй өсөж байна. Бор-Өндөр сум нь хүн амын тоогоор аймагтаа тэргүүлдэг ордог. Хүн амын нягтралаар хамгийн өндөр буюу 60.99 хүн/га байна. Бор-Өндөр сумын 1-р баг Бор Өндөр, 2-р баг Холбоо, 3-р баг Бумбат, 4-р баг Уурхайчин, 5-р баг Хүйх, 6-р баг Өлгий гэсэн нийт 6-н багтай. Зургаан багийн нийт 2439 өрх, 9119 хүн амтай. Нийт хүн амын 4600 нь эрэгтэй үүний 275 нь хөдөөгийн иргэд, 4519 эмэгтэй үүний 239 нь хөдөөгийн иргэд байна. Тус суманд Халх, Казах, Дөрвөд, Буриад, Торгууд, Урианхай, Дарьганга, Үзэмчин зэрэг олон ястан үндэстэн амьдардаг.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны явцад агаарын чанарт нөлөөлөх гол эх үүсвэр нь уулын ажил, тээвэрлэлт болон тоног төхөөрөмжийн ажиллагаанаас үүсэх тоосжилт, утаа юм. Үүнд хүдрийн олборлолт, овоолгоос үүсэх тоосжилт болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэлтэй замын тоосжилт голлон нөлөөлнө. Мөн баяжуулах үйлдвэрт хүдэр тээвэрлэх автомашины хөдөлгөөн болон уурхайн техник, тоног төхөөрөмжийн яндангаас ялгарах хорт хий нь агаарын бохирдолд тодорхой хэмжээгээр нөлөөлөх боломжтой.

Нөлөөллийн үнэлгээгээр эдгээр нөлөөлөл нь ихэвчлэн багаас дунд зэргийн эрчимтэй, дунд хугацаанд үргэлжлэх шинжтэй гэж үзэгдсэн.

3.2. Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны явцад уурхайн талбай, барилга байгууламж, зам талбай байгуулах, тээвэрлэлт хийх зэрэг ажлаас шалтгаалан газрын гадарга эвдрэх, шимт хөрс хуулалт явагдах, хоосон орон зай үүсэх зэрэг сөрөг нөлөөлөл үүснэ. Мөн хөрсний овоолго, техник, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрсний бүтэц алдагдах, талхагдах нөлөөлөл илэрч болзошгүй. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал, шатах тослох материалын асгаралт зэргээс хөрсний бохирдол үүсэх эрсдэлтэй.

Нөлөөллийн үнэлгээгээр эдгээр нөлөөлөл нь ихэвчлэн багаас дунд зэргийн эрчимтэй, дунд хугацаанд үргэлжилнэ.

3.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны явцад барилга байгууламж, зам талбай, овоолго үүсэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шалтгаалан ургамлан нөмрөг доройтох, устах, талхлагдах сөрөг нөлөөлөл үүсэх боломжтой. Мөн тоосжилтын нөлөөгөөр ургамлын навч, иш бохирдож, фотосинтезийн үйл ажиллагаа буурах, ургалт саарах нөлөөлөл илэрч болзошгүй. Түүнчлэн хөрсний эвдрэл, хээржих үйл явц нэмэгдэх нь ургамлын бүтцэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Нөлөөллийн үнэлгээгээр ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь ихэвчлэн багаас дунд зэргийн эрчимтэй, дунд хугацаанд үргэлжилнэ.

3.4. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хүний үйл ажиллагаа нэмэгдэх, дуу чимээ үүсэх зэргээс шалтгаалан амьтдын амьдрах орчинд нөлөөлж, үргэх, дайжих сөрөг нөлөөлөл үүсэх боломжтой. Мөн зам талбай, барилга байгууламж, олборлолтын үйл ажиллагааны нөлөөгөөр амьдрах орчин доройтож, зарим амьтдын байршил өөрчлөгдөх, жижиг амьтад өртөж хорогдох эрсдэлтэй. Хог хаягдал, бохирдлоос шалтгаалан амьтдын идэш тэжээлийн орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Нөлөөллийн үнэлгээгээр амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь ихэвчлэн бага, зарим тохиолдолд дунд зэргийн эрчимтэй, дунд хугацаанд үргэлжлэх шинжтэй байна.

3.5. Гадаргын болон гүний усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны явцад гадаргын усанд шууд нөлөөлөл бага боловч гүний усны нөөцөд тодорхой хэмжээний сөрөг нөлөөлөл үүсэх боломжтой. Ахуйн болон үйлдвэрлэлийн ус ашиглалт нэмэгдэх, шүүрлийн ус үүсэх, хог хаягдал болон шатах тослох материалын зохисгүй менежментээс шалтгаалан гүний болон гадаргын ус бохирдох эрсдэлтэй. Мөн хөрсөөр дамжин бохирдуулагч бодис усанд нэвчих боломжтой.

Нөлөөллийн үнэлгээгээр усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь ихэвчлэн дунд, зарим тохиолдолд бага зэргийн эрчимтэй, дунд хугацаанд үргэлжлэх шинжтэй байна.

3.6. Нийгэм, эдийн засгийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн хэрэгжилтийн явцад хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэх, дуу чимээ, хөдөлгөөнөөс шалтгаалан орон нутгийн иргэдийн амгалан тайван байдалд нөлөөлөх, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэл үүсэх, зарим тохиолдолд нийгмийн үйлчилгээний ачаалал нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөллүүд илэрч болзошгүй байна. Мөн малчдын бэлчээрийн талбайд тодорхой хэмжээний хязгаарлалт үүсэх, зам тээврийн хөдөлгөөн нэмэгдэх, хог хаягдлын зохисгүй менежментээс орчны бохирдол үүсэх эрсдэлтэй.

Нөлөөллийн үнэлгээгээр дээрх сөрөг нөлөөллүүд нь ихэвчлэн бага, зарим тохиолдолд дунд зэргийн эрчимтэй, орон нутгийн түвшинд илрэх шинжтэй байна.

3.7. Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Бор-Өндөрийн хайлуур жоншны хүдрийн 16-1 биетийг далд аргаар ашиглах төсөл нь гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан

бүхий газрын хилийн зааг, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хил заагтай давхцалгүй байна.

3.8. Түүх соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Бор-Өндөрийн хайлуур жоншны хүдрийн 16-1 биетийг далд аргаар ашиглах төслийн талбайд түүх дурсгалын зүйлс болон археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй байна. Гэсэн хэдий ч цаашдын үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор илэрвэл төсөл хэрэгжүүлэгч энэ талаар орон нутгийн захиргаа болон мэргэжлийн байгууллагад мэдэгдэж зохих арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

3.9. Цацраг идэвхт бодисын нөлөөлөл

Төслийн талбайд хийсэн лабораторийн шинжилгээний дүнгээр хөрсний цацрагийн үзүүлэлтүүд нь байгалийн дундаж түвшинд, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байна. Иймд төслийн үйл ажиллагаанаас үүдэн цацраг идэвхт бодисын нөлөөлөл үүсэхгүй, хүн ам болон байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлгүй гэж дүгнэсэн.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн хэрэгжилтийн явцад үүсэх байгаль орчны сөрөг нөлөөллийг урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх, орчны хяналт-шинжилгээг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагыг ханган ажиллахад чиглэсэн төлөвлөлтийн баримт бичиг болно.

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь:

- Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах
- Байгалийн нөөцийг зохистой ашиглах
- Орчны хяналт-шинжилгээг тогтмол хэрэгжүүлэх
- Байгаль орчны хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангах
- Төслийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах

4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулсан аргачлал

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчныг хамгаалах хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ууд болон Байгаль орчны Сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хянан батлах тайлагнах” журам, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачилсан заавар”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шинжилгээ хийх журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ” зэргийг удирдлага болгон ажилладаг.

БОМТ боловсруулахдаа дараах дарааллын дагуу гүйцэтгэсэн.

1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнг нэгтгэн дүгнэх
2. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох
3. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг боловсруулах
4. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулах
5. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал, хугацаа, хэрэгжүүлэгчийг тодорхойлох
6. Оролцогч талуудын оролцоог хангах, санал тусгах

Энэхүү төлөвлөгөө нь уурхайн үйл ажиллагаа явуулах хугацаанд мөрдөгдөнө.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар					
Уурхайн бэлтгэл ажлын үед шороон зам, талбайгаас тоосжилт үүсэж агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Уурхайн олборлолт, хөрсний овоолго үүсгэх, түр шороон замаар тээвэрлэлт хийх үед усалгаа хийх	Босоо гол ам, хөрсний овоолго, зам	3.0	Жил бүр 5-9 сард салхи, хуурайшилт ихтэй өдрүүдэд	MNS 4585:2016 Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 5885-2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
	Уурхайн дотоод шороон замыг тогтмол засаж сайжруулах, нягтаршуулах	Уурхайн дотоод зам	Үйл ажиллагааны зардлаар	Жил бүр	
	Уурхайн тээвэрлэлтийн замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн тээвэрлэлтийн зам	Үйл ажиллагааны зардлаар	Тээвэрлэлтийн туршид	
	Уурхайн түр шороон зам дагуу MNS 4597:2014 стандартын дагуу замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Уурхайн тээвэрлэлтийн зам	3.56	2026 онд	
	Уурхайн замд тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах зохицуулалт хийх (уурхайн дотоод зам дээр ачаатай тээвэрлэлт хийхдээ хурдны хязгаарыг 20 км/цагт тогтмол барих ба ачаагүй үед хурдны	Уурхайн дотоод зам	Үйл ажиллагааны зардлаар	Тээвэрлэлтийн туршид	

	хязгаарыг 30 км/цагт барих)				
	Уурхайн олборлолтын талбай, түр зам, ажилчдын кемп зэрэг газруудад агаарын тоосжилтын хэмжилтийг тогтсон хуваарийн дагуу хийх, хэмжилтийн үр дүнг хянаж, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тоос бууруулах арга хэмжээг авах	Гол ам, уурхайн түр зам, ажилчдын кемп	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.	Жилд 2 удаа	
	Тээврийн хэрэгслүүдийн орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс засвар үйлчилгээг тогтмол хуваарийн дагуу хийх, ашиглалтын хугацаа дууссан, утаа ихээр ялгаруулдаг машин техникийг үйл ажиллагаанд ашиглахгүй байх	Машин техникүүд	Үйл ажиллагааны зардлаар	Жил бүр	
Усан орчин					
Усны эх үүсвэр бохирдох эрсдэл	Усны чанарт (pH, EC, TDS) лабораторийн шинжилгээ хийлгэж хяналт тавих	Усны эх үүсвэр	2.0	Жил бүр	MNS 0900-2018, “Ундны усны чанарын стандарт” Ус ашигласны төлбөр (Засгийн газрын 2005 оны 7-р тогтоол) MNS 4943:2015, “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус

	Ус ашиглах гэрээ, боломжит нөөцийн дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх	-	Үйл ажиллагааны зардлаар	Жил бүр	
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч					
Хог хаягдлаас хөрс бохирдох, тархах Тос, шатахуун асгаралтаас хөрс бохирдох Уурхайн үйл ажиллагаанаас хөрсний эвдрэл үүсэх	Хог хаях, шатах тослох материал асгах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Бүх жолооч нарт	1.0	Жилд 1 удаа	MNS 5916-2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”, MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 5850-2019, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
	Автомашин зогсоолыг цементэн хучилттай болгох	Бүх зогсоол	1.5	2026	
	Асгаралт шингээгч материал (песок, сорбент) ашиглан бохирдлыг шуурхай цэвэрлэх, бохирдсон хөрсийг зайлуулах	Засварын талбай	0.6	Тухай бүр	
	Шимт хөрсийг олборлолтын өмнө хуулж тусад нь хадгалах, дараа ашиглах нөхцөлийг бүрдүүлэх	Олборлолтын талбай	Дотоод зардлаар	Ажил эхлэх үед	
Нийт дүн сая.төг			11.66		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийг хаалтын үед хийх буюу хаалтын төлөвлөгөөнд багтаана. 2026 онд Биологийн нөхөн сэргээлт болон тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд өөрийн зардлаар 2000 мод тарина мөн техникийн нөхөн сэргээлт энэ онд хийгдэхгүй тул тусгаагүй.

Хүснэгт 2. Нөхөн сэргээх талбайн хэмжээ

№	Талбайн нэр	Хэмжээ, га	Хийгдэх ажил	Зардал мян.төг
1	Эзэмшлийн талбайд, орон нутгийн төлөвлөсөн талбайд	0.02	3000 мод тарина	Өөрийн зардлаар

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

